

**ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН:** “Ялгуусан”ХХК-ийн

Захирал...../Л.Санжаадорж/

**Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн  
нутаг дахь “Улаан чулуут” алевро элсэн чулууны  
ордын 2022 оны Байгаль орчны менежментийн  
төлөвлөгөөний биелэлтийн тайлан  
( Тусгай зөвшөөрөл MV-016793)**

**ХЯНАЖ , ХҮЛЭЭН АВСАН:**

НБОГ-ын Хүрээлэн буй орчин Байгалийн нөөцийн хэлтсийн мэргэжилтэн:

...../Ж.Батзолбоо/

Боловсруулсан:

Инженер: ...../Ж.Цолмон/

Улаанбаатар хот  
2022 он

***Байгаль орчны менежментийн тухайн жилийн  
төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн агуулга***

Төслийн товч танилцуулга

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт
9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт
10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт
11. Дүгнэлт

## ТӨСЛИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

**Төслийн нэр:** “Улаан чулуут” алевро-элсэн чулууны ордыг ил аргаар ашиглах

**Төсөл**

**хэрэгжүүлэгч:** “Ялгуусан” ХХК

**Төсөл хэрэгжүүлэх**

**үйлдвэрийн**

**байршил:**

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 5-р хороо, Жалханхутагт Дамдинбазарын гудамж өөрийн байр.

Улаанбаатар хотын баруун хойд зүгт Бага Нарангийн амны зүүн талд байрлана.

Талбайн солбицлууд:

1. 106° 46' 25" д.у 47° 57' 36.77" х.ө

2. 106° 46' 25" д.у 47° 58' 01.78" х.ө

3. 106° 47' 07.34" д.у 47° 58' 01.77" х.ө

4. 106° 47' 07.34" д.у 47° 57' 36.77" х.ө

**Төсөл хэрэгжүүлэгч**

**байгууллагын хууль**

**эрх зүйн хүчинтэй**

**баримтуудын**

**жагсаалт:**

Улсын бүртгэлийн гэрчилгээ

Улсын бүртгэлийн дугаар: 9011029034

Улсын регистрийн дугаар: 2112663

Улсад бүртгүүлсэн: 2006-05-30

“Улаан чулуут” алевро-элсэн чулууны ордод 2009 онд явуулсан хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцсэн тухай Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн дүгнэлт

Дугаар: ХХ-04-07

Он сар: 2010-04-08

ТЭЗҮ хүлээн авсан ЭБМЗ-ийн дүгнэлт

Дугаар: т/07-08

Он сар: 2011-07-07

ТЭЗҮ хүлээн авсан АМГ-ын даргын тушаал

Дугаар: Т/526

Он сар: 2011-12-05

Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл

Дугаар: MV-016793

Олгосон: 2011-03-16

Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлийн хүчинтэй хугацаа

Он сар: 2041-03-16

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### Ордын районы физик-газарзүйн нөхцөл

“Улаан чулуут” алевр-элсэн чулууны орд нь Улаанбаатар хотын баруун хэсэгт Бага Нарангийн амны зүүн уул Толгой уулын урд үзүүрт оршино.

“Ялгуусан” ХХК-ийн MV-016793 тусгай зөвшөөрөлтэй 68 га талбай нь байр зүйн зургийн L-48-10 хавтгайд орших ба булангийн эргэлтийн цэгүүдийн газар зүйн солбилцол нь:

Зүүн уртраг ( $\lambda$ )	Хойд өргөрөг ( $\phi$ )
1. $106^{\circ} 46' 25''$	$47^{\circ} 57' 36.77''$
2. $106^{\circ} 46' 25''$	$47^{\circ} 58' 01.78''$
3. $106^{\circ} 47' 07.34''$	$47^{\circ} 58' 01.77''$
4. $106^{\circ} 47' 07.34''$	$47^{\circ} 57' 36.77''$

Газарзүйн хувьд орд нь Хэнтийн уулархаг мужийн баруун урд хэсэгт багтах бөгөөд эх газрын эрс тэс уур амьсгалтай. Усан сүлжээний хувьд ордын дүүрэг нь Туул гол түүний цутгалуудаас бүрдэнэ. Орд нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт орших тул уур амьсгалын хувьд нэг адил, жилийн хамгийн хүйтэн хугацаа нь 1-2-р сарууд бөгөөд эдгээр саруудад агаарын температур нь  $-20^{\circ}\text{C}$ -с  $-25^{\circ}\text{C}$  хүрэх ба зарим тохиолдолд хааяа  $-35^{\circ}\text{C}$ , хамгийн дулаан нь 7-р сард  $+25^{\circ}\text{C}$ -с  $+30^{\circ}\text{C}$ , заримдаа  $+35^{\circ}\text{C}$  хүрнэ. Хөрсний хөлдөлтийн гүн нь дунджаар 3-4 м-т хэлбэлзэнэ. Энэ дүүрэгт Улаанбаатар хотын нэг адилаар салхи ихэнхдээ баруун, баруун хойноос чиглэлтэй салхилах бөгөөд салхины хурд нь гол төлөв 1-5 м/сек орчим байна.

Физик газарзүйн мужлалын хувьд Төв Монголын Хангай Хэнтийн мужид хамрагддаг бөгөөд үнэмлэхүй өндөр нь далайн түвшингээс дээш 1100-1800 м хүрдэг. Ус зүйн хувьд Төв Азийн гадагшаа урсгалтай ай савд багтана. Хүн амын суурьшил их бөгөөд дэд бүтэц сайн хөгжсөн.

### Ордын районы геологийн судалгааны товч түүх

Улаанбаатар хот орчмын геологийн судлалгаа үндсэндээ 1925 оноос ЗХУ-ын Шинжлэх ухааны академи ба БНМАУ-ын Шинжлэх ухааны хорооны хамтарсан экспедицүүд байгуулагдан судалгаа явуулснаар эхэлсэн гэж үздэг. 1930 онд БНМАУ-ын Засгийн газрын хүсэлтээр ЗХУ-ын ШУА-ийн ажилтан З.А.Лебедев Улаанбаатар хот, түүний орчмын талбайд М1:1000000 - ны масштабтай геологийн зураглал хийсэн

байна. 1966-1967 онуудад геологичид Л.Гомбосүрэн, Б.Жамбаа нар Улаанбаатар хотын баруун талаар М1:200000 -ны масштабтай геологийн зураглалын ажил хийжээ.

2009 оны 7-р сард "Ялгуусан" ХХК-ний хүсэлтээр геологи Ш.Доржсүрэн нар Улаан чулуут алевро-элсэн чулууны ордод хайгуулын ажил хийж нөөцийг АМГ-ын даргын 2010 оны 05 сарын 10-ны өдрийн 188 тоот тушаалаар ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлжээ.

### **Улаан чулуут ордын геологийн тогтоц**

Улаан чулуутын орд нь Сонгино хайрхан дүүргийн нутагт орших бөгөөд энд Туул голын хойд талаар тархсан дунд палеозойн настай тунамал терриген хурдас болох ногоовтор саарал, хар саарал өнгийн дунд-жигжиг ширхэгтэй алевро-элсэн чулуу/алевролит-элсэн чулуу/, хар саарал өнгийн аргиллит, алевролит, хар өнгийн хуудсархаг кристаллаг занар голчлон тархсан байна.

Ордын талбайн геологийн тогтоц энгийн нэгэн төрлийн найрлагатай дунд зэргийн ширхэгтэй алевро-элсэн чулуу, кристаллаг занарын нарийн үелэлтэй хэсэг тархсан байна. Талбайн хойд хэсгээр 232-285 градусын суналын азимуттай аплит маягын нарийн ширхэгтэй боржингын дэл судал зүсч 5-15м-ийн зузаантай байна.

Нөөц бодсон талбайн 99.0%-д тархсан алевро-элсэн чулуу нь гүндээ бор саарал өнгөтэй маш хатуу нягт жижиг-нарийн ширхэгтэй, өгөршсөн хэсэгтээ ногоовтор саарал өнгөтэй ширхэглэлийн хэмжээ нилээд тодорч жижиг-дунд зэргийн гэж хэлж болохоор, хатуу цул текстуртэй, хувиралд ороогүй, чулуулгын ерөнхий унал нь хойш, зүүн хойш чиглэлтэй, чулуулгын ан цав, хагарлын ерөнхий чиглэлийг судлахад баруун хойш чиглэлийн суналтай хагарал голчлон ажиглагдах бөгөөд ан цав хагарал нь 275-320 градусын хагаралын суналын азимутаар 55-75 градусын уналын өнцөгтэй байна.

## **ДЭД БҮТЭЦ БА БУСАД ПРОЦЕССУУД**

### **Уурхай ба тосгоны гадаад дотоод цахилгаан хангамж**

Уурхай ба боловсруулах үйлдвэр нь нэг ээлжээр улирлын чанартай ажиллах тул уурхайд гэрэлтүүлэг шаардлагагүй болно. Уурхай болон үйлдвэрлэлийн гол хэрэглэгч нь цехийн контор, ажилчдын цайны газар, сахиулын байр ахуйн хэрэглээ, бутлан ангилж боловсруулах үйлдвэр зэрэг болно.

### **Уурхай ба тосгоны дулаан ба усан хангамж**

Уурхай ба боловсруулах цех нь нүсэр бүтэцгүй улирлын чанартай 1-ээлжээр ажиллах учир уурхай дээр овор бага вагончик юмуу энэ хэлбэрийн барилга байгууламж баригдах ба тусгайлсан дулаан хангамж шаардлагагүй юм. Мөн уурхай нийслэл хотын дэргэд байгаа учир ажиллагсад гэрээсээ компаний үйлчилгээний бага оврын автобусаар ажилдаа ирж очихоор зохицуулагдана. Гэхдээ ажиллагсдын хоол цайг одоо үед өргөн хэрэглээ болж буй шингэрүүлсэн хийн түлш /газ/-ээр хийх ба контор, сахиулын гэр байр зэргийг зах зээл дахь утаагүй шахмал түлш, мод зэргээр энгийн ахуйн дулаан хангах хэлбэрээр зохицуулна.

### **Усан хангамж, үер усны хамгаалалт**

Уурхай боловсруулах цех, замын усалгаанд хэрэглэгдэх усны хангамжийг гүний худагаас авна. Усны хэрэгцээний тооцоог дараах байдлаар хийв. Замын усалгааг ЗИЛ-130 машинд суурилагдсан ТЦ10 маркийн тусгай зориулалтын автомашинаар хийнэ. Технологийн замыг услах усны тооцоо: Замыг нэг ээлж услахаар тооцоолов.

### **Цэвэрлэгээ, ариутгалын систем**

Уурхай үйлдвэрийн дэргэд ахуйн болон бусад хог хаягдалыг хаях цэг, ОО-ыг байгуулан орчныг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч эмх цэгцтэй байлгах шалгалт ариутгалыг нийслэл дүүргээс гаргасан дүрэм журмыг тухайн хугацаанд нь мөрдлөг болгон ажиллах нь зүйтэй. Ариутгалыг мэргэжлийн байгууллагаар болон өөрсдөө гүйцэтгэх бололцоотой эсэхийг судалж гэрээ хэлэлцээр хийх зэргийг жилийн уулын ажил, үйлдвэрлэлийн төсөл төлөвлөгөөнд тусгаж тооцож ажиллана.

## **Уурхайн засвар, техникийн үйлчилгээ**

Уурхай ба буталж ангилах үйлдвэрийн засвар үйлчилгээг компанийн Хан-Уул дүүргийн нутагт орших үйлдвэр баазын механик цехээс зохицуулан гүйцэтгэнэ. Засварын цех нь бүтэн жилийн турш ажилладаг компанийнхаа зам засвар, зам тавилтын нэгжүүддээ суурин болон явуулын хэлбэрээр үйлчилдэг юм. Энэ цехэд гүйцэтгэж чадахгүй зарим зүйлийг хийж чадахуйц газар, компаниудад захиалга, гэрээ хэлцлээр зохицуулан гүйцэтгэнэ.

## **Хүний нөөц**

Уурхай боловсруулах үйлдвэрт ажиллах инженер техникийн ажилчдыг “Ялгуусан”ХХК-д ажиллаж буй олон жилийн дадлага туршлагатай инженер техникийн ажилчид болон мэргэжлийн баг бүрдүүлэх ба ажиллах хүчний хэсгийг Улаанбаатар хотын дүүргүүдээс бүрдүүлэх чиглэлийг барина. Ингэснээр ажилгүйдлийг багасгах, мэргэжилтэй ажилчдыг сургаж, бэлтгэх ач холбогдолтой болно. Шаардлагатай гэж үзвэл нарийн мэргэжлийн ажилчдыг Герман улсаас урьж ажиллуулна. Уурхай үйлдвэр нь хүчин чадал бага, бүтэц зохион байгуулалтын хувьд нүсэр биш учир уурхай боловсруулах үйлдвэрт 20-25 хүн ажиллах ба үүнээс ИТА-5 байна.

## **Нөхөн сэргээлтийн ажилд баримтлах стандартууд**

Монгол улсын зохих хууль, стандарт дүрмүүд, тушаал шийдвэрүүдийн дагуу байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн ажил хийгдэнэ. Зохих хууль дүрэм,стандартуудыг хэрэгжүүлэхдээ “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт MNS5914:2008” стандартыг голчлон баримтлана. “Уул, уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаар эвдэрсэн газрын ангилал” MNS5915:2008, ”Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт”MNS5916:2008, ”Уул, уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаар эвдэрсэн газрын ангилал”MNS5917:2008, ”Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага”MNS5918:2008 гэх мэт стандартуудыг мөрдөж ажиллана.

## **Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл**

- Уурхайн эдэлбэр газрын агаарын бохирдолтыг аль болох бага байлгах үүднээс уурхайн авто замуудыг дулааны улиралд тогтмол услах тоосжилт бага байлгах тал дээр анхаарч усалгаа хийж чийгшүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр шинэчлэн гаргаж батлуулан төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж явах бөгөөд түүнд гарах зардлыг нөхөн сэргээлт байгаль хамгаалах зардлын тооцоо хэсэгт тодорхой тусгасан болно.
- Уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг хийхдээ гадаад овоолгод дарагдах талбайг боломжит хамгийн бага байлгах зорилгод тулгуурласан байгаа.
- Ашиглалтын явцад зөвхөн технологийн процессуудад зайлшгүй шаардлагатай замуудыг байгуулан, маршрутыг тогтоож, тоног төхөөрөмжүүдийг парклах талбайнуудыг тусгайлан байгуулах замаар онц шаардлагагүй олон салаа зам гарч газрын гадарга эвдэгдэхээс сэргийлнэ гэж үзэж байна. Зам, талбайд ашиглагдах нийт талбайг уурхайн ашиглалт дууссаны дараагаар нөхөн сэргээнэ.

### **Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх талаар явуулах үйл ажиллагаа нь дараахь талбаруудад чиглэгдвэл зохино.**

Үүнд:

- Талбайн хөрсний усыг бохирдуулахгүй байх арга хэмжээ авах.
- Газрын хэвлийд үүссэн хоосон орон зай, ил уурхайн карьер зэрэгт тэмдэг тэмдэглэгээг сайн хийж өгөх,
- Уурхайн дэд бүтцийн барилга байгууламжийг барьж байгуулах явцад болон төслийн хэрэгжилтэнд ашиглах хүнд машин механизм, тээврийн хэрэгслүүдийг түр болон зөвхөн зааж өгсөн замын маршрутаар явуулах, тоосжилтыг багасгах үүднээс замыг услаж байх.
- Талбайд үүсэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цэвэрлэх.
- Гал түймрээс сэргийлэн сонор сэрэмжтэй ажиллана. Галын аюулаас урьдчилан сэргийлэх зааварчилгааг ажиллагсадад бүрэн өгч, гал түймрийн үед ажиллах зохион байгуулалт хийж мөрдөх.
- Эвдэрсэн газрыг тарималжуулах ургамлын төрөл зүйл, тариалах арга ажиллагааг тухайн талбайн хөрсний шинж чанар, бүтэц болон газрын гадаргын налуу болон бусад нөхцөл байдалтай уялдуулан сонгох бөгөөд үр суулгац тариалах ажлыг ургамал ургах хамгийн тохиромжтой хугацаанд явуулах.



## **Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт**

Энэхүү төлөвлөгөө нь "Ялгуусан" ХХК-ийн Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт Улаан чулуут алевро-элсэн чулууны ил аргаар олборлох төслийн ашиглалтын үе шатанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилготой юм.

Байгаль орчныг хамгаалах чиглэлээр аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг:

- Байгаль орчныг хамгаалах чиглэлээр өөрийн ажилтан ажилчдын дунд сургалт, семинарыг жилд нэг удаа тогтмол зохион байгуулах,
- Гал түймэр, үер усны аюул зэрэг байгалийн гай гамшгийн үед авагдах арга хэмжээний зөвлөмжийг гаргаж, үйл ажиллагаандаа мөрдлөгө болгох,
- Байгаль орчин, хүрээлэн байгаа орчноо хайрлан хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллийг таслан зогсоох үзэл баримтлалыг нийт ажилтан, ажилчдын оюун ухаанд төлөвшүүлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах,
- Жил бүр ажлын төлөвлөгөөндөө байгаль хамгаалах, нөхөн сэргээх сөрөг нөлөөллийг таслан зогсоох зардлыг тусган төлөвлөж ажиллах.

## 1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Карьер нээх, овоолго хийх , дайрга олборлох, тээвэрлэх, ангилан ялгах үйл ажиллагаагаар хөрс эвдэрч бохирдохоос гадна шатах, тослох материал болон шингэн хаягдал хөрсөнд нэвчих замаар бохирдол үүсч болзошгүй. Бохирдлын эх үүсвэр нь бохирын цэг, хатуу хог хаягдал, ахуйн химийн бодис (угаалгын нунтаг, саван, шампунь) зэрэг болно. Уурхайд ажиллагсад, ойр орчинд байгаа хүн, мал, бичил амьтан, ургамал амьтан зэрэг нь нөлөөлөлд өртөх объект болно. Байгаль орчинд бохирдол үүссэн тохиолдолд бохирдол нь ургамал, хөрсөөр дамжин хүрээгээ тэлэх магадлалтай. Эвдэрсэн газар, хөрсийг стандарт MNS 5917:2008-ын дагуу нөхөн сэргээнэ. Хөрсийг химийн бодисоор бохирдуулах, шатах тослох материал ил задгай асгахыг хориглоно. (БОЯ, ЭХЯ-ны сайдын 1989.06.22-ны 68/А/61 дугаарын тушаал). Газар ашиглалтын бүртгэл мэдээг хөтөлж, холбогдох байгууллагад орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт заасан хугацаанд тайлагнана.

### **Агаар орчны бохирдол:**

Хатуу, шингэн хог хаягдлыг ил задгай хаяснаас элдэв гаж үнэр гарах, тоосжилт, угаа тортог, CO, SO<sub>2</sub>, NO<sub>2</sub>-ын хэмжээ ихэсч болзошгүй. Агаарын бохирдол нь ордод ажиллагсад, ойр орчимд буй хүн, мал, амьтан, ус, ургамал, хөрсөнд нөлөөлж болзошгүй. Эрүүл ахуйн хяналтын ерөнхий байцаагчийн тушаалаар батлагдсан “Хот суурингийн агаар дахь хорт бодисын агууламжийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг” (Улсын ариун цэврийн байцаагчийн 1989 оны 11 тоот тушаалын 2-р хавсралтаар) баримтална. Агаарын шинжилгээг орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт заасны дагуу хийлгэж байх болно.

### **Усны бохирдол:**

Ил уурхайн ашиглалтын түвшинд гүний ус илрээгүй бөгөөд жилийн аль ч улиралд гүний худгаас ахуйн усны хэрэглээг хангах болно. Тус худгийн ус нь ундны усны MNS 9000:2010 стандартыг хангаж байгаа. Бохирдлын эх үүсвэр нь бохирдсон ус, жорлон, бохирын цэг, шатах, тослох материал, машин тэрэг угаах , ахуйн бохир ус зэрэг болно. Дээрх эх үүсвэрүүд нь газар доорх усыг шууд ба шууд бусаар бохирдуулах, горимд өөрчлөлт оруулах магадлалтай. Ус бохирдоход ордод ажиллагсад , ойр хавийн хүн, мал, ан амьтан өртөх эрсдэлтэй. Ундны усны чанарын УСТ900-92 стандарт , гадаргын болон газар доорх усны ариун цэврийн хамгаалалтын бүсийн дүрэм , журмыг баримтална. Усны шинжилгээг орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт заасны дагуу хийлгэж байх болно.

## Ургамлын бүрхэвчийн бохирдол:

Бохирдолын эх үүсвэр нь авто хөсөг болон бусад өөрөө явагч машин механизм дураараа зорчих, шатах тослох материал ил задгай асгаснаас үүсэх бохирдол нь ургамлын бүрхэвчийг бохирдуулах гол шалтгаан тул хамгаалалтын бүсийн дүрэм журам боловсруулж ажиллах шаардлагатай.

## Сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Биелэлт
<b>1. Агаарын чанар</b>			
1.1	Агаарын чанар Улаанбаатар хотын Цаг уур, орчны шинжилгээний газарт хийлгэсэн	100.0	Хяналт шинжилгээний хөтөлбөрт заасны дагуу 2 удаа хийлгэв. Агаарын чанарт ямар нэгэн өөрчлөлт байхгүй
	Нийт зардал /мян.төг/	<b>100.0</b>	
<b>2. Газрын гадарга, газар доорх усан орчин</b>			
2.1	Уурхайн дотор болон уурхайн ойр орчимд хатуу ба шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүн хаяхгүй байх (урьдчилан сэргийлэх арга хэмжээнд)	Дотоод зардлаар	Хог хаягдлын цэг байгуулсан. Уурхайд ундны усны худаг гаргасан ба худгийн усыг ус цэвэршүүлэгч хэрэглэн ундны усанд хэрэглэж байна.
2.2	Усны шинжилгээ хийлгэнэ.	150.0	
	Нийт зардал /мян.төг/	<b>150.0</b>	
<b>3. Хөрсөн орчин</b>			
3.1	Хатуу хог хаягдал ахуйн хаягдал эмх цэгцтэй хадгалах хог хаягдалын цэг байгуулсан.	300.0	Хот тохижолтын газартай гэрээ хийж стандартын шаардлага хангасан хогийн савнуудыг худалдан авч уурхайн дээр байрлуулсан бөгөөд тээвэрлэлтийг өөрсдөө хариуцах болсон.
3.2	Техникийн засвар үйлчилгээг тусгай талбайд явуулах	250.0	
3.3	Хөрсний шинжилгээг ОХШ хөтөлбөрт заасан хугацаанд ЦУОШГазрын лаборатороор хийлгэсэн	140.0	
3.4	Тээвэрлэлтийн зам болон уурхайн тоосжилтыг тухай бүрт хийж байлаа.	240.0	
	Нийт зардал /мян.төг/	<b>930.0</b>	
<b>4. Ургамлан нөмрөг</b>			
4.1	Уурхайн олборлолтын талбай ургамал талхлагдсан газруудад хамгаалалт хийж, байгаль өөрөө сэргэх боломжийг бүрдүүлэх	Дотоод зардлаар	Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээг бүрэн хашаажуулж уурхайн талбай дундуур гардаг замыг өөрчилж олборлолтын болон дотоод тээвэрлэлтийн нэгдсэн замтай болсон
	Нийт зардал /мян.төг/	<b>0</b>	
<b>Бүгд зардал /мян.төг/</b>		<b>1180.0</b>	

## **2.НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй болно.

## **3.БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗЫН БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Нийслэлийн Байгаль Орчины Газартай хамтран ажиллана 2022 онд төлөвлөсөн дүйцүүлэн нөхөн сэргээх ажлын зардал болох 2 880 000 төгрөгийг, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангуулж ажиллахаар нийслэлийн нутаг дэвсгэрт нэгдсэн зохион байгуулалтаар шилмүүст мод тарих ажилд зарцуулах НБОГ-тай гэрээ байгуулсан “Мөнххантайшир”ХХК-нд манай компани нь “**2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**”-ний дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний ажилд зарцуулах зардлыг шилжүүлэн тус арга хэмжээнд хамтран ажилласан.

Жич: мөнгөний шилжүүлсэн баримтын хуулбарыг тайланд хавсрагав.

## **4.НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

Төсөл хэрэгжүүлэх талбайн хүрээнд болон төслийн хамгийн их нөлөөлөл бүхий бүсэд суурин айл өрхүүд байхгүй тул одоогоор ямар нэг нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын ажил төлөвлөгдөөгүй болно.

## **5.ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

## **6.ОСОЛ,ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Төслийн талбайд байрлуулсан галын хор болон бусад галын хамгаалах багаж хэрэгсэлд бүрэн бүтэн байдал аюулгүй ажиллагаанд хяналт тавьж ажиллав.

Ажлын хувцасны чанарын үзүүлэлтийн жагсаалт УСТ-0012.4016.89/ /MNS/-ыг баримтлан ажлын хувцас мөн хамгаалах хэрэгслийн жагсаалт, эдэлгээний хугацааг баталсан тогтоол шийдвэр баримтлан. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг шаардлагын дагуу ханган нийлүүлэн.

Байгаль орчныг хамгаалах, ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалт зохион байгуулах.

## **7.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Стандартын шаардлага хангасан хогийн савнуудыг худалдан авч уурхайд байрлуулсан бөгөөд тээвэрлэлтийг “Ялгуусан” ХХК өөрөө хариуцах болсон.

## **8.УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТ**

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу дээрх болон доор дурьдсан ажлуудыг зохион байгуулж хийж гүйцэтгэсэн болно.

Байгаль орчныг хамгаалж, нөхөн сэргээхэд Улаан чулуут ордыг ашиглах төслийн нарийвчилсан үнэлгээ, төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, нөхөн сэргээх төсөл, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу ажиллана.

- Уурхайн хүчин чадал бага тул удирдлагын нүсэр бүтэц байх шаардлагагүй юм. Иймд байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг уурхайн дарга хариуцан гүйцэтгэх бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана.
- Нөхөн сэргээлт болон дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх.
- Байгаль орчныг хамгаалах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийлгэсэн дүнг заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргэж тайлагнаж байна.

**Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал Мян.төг	Хариуцаг ч
1	Болзошгүй аюул ослын үед дүүргийн эмнэлэг бусад байгууллагатай хамтран ажиллах	Жил бүр	360.0	инженер
2	Ойн хээрийн түймрээс сэргийлэх, унтраах хэрэгслээр хангах, ажиллагсдыг түймэр унтраах арга барилд сургах, гал түймэр гарсан тохиолдолд шуурхай унтраах арга хэмжээ авах, байгаль хамгаалагчид туслах.	Олборлолтын хугацаанд	150.0	Компаний захиргаа
<b>Дүн</b>			<b>510.0</b>	

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын ажилд энэ жил 510 мян.төгрөг зарцууллаа.

**9.ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТ**

Энэ оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Сонгинохайрхан дүүргийн 36 дугаар хорооны оршин суугчидтай болон дүүргийн байгаль орчны байцаагч, холбогдох албадын хүмүүст танилцуулан ажиллаж байгаа. 09-р сард дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний үед Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг танилцуулна компанийн тайлан мэдээллийг танилцуулан ажиллав.

## 10.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

2022 онд Улаанбаатар хотын Цаг уур, орчны шинжилгээний газарт хийлгэх хөтөлбөрт тусгагдсан бүх шинжилгээг хийлгэсэн.

Байгаль орчны бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээний ажил	Холбогдох стандартууд	Шинжилгээ хийх лаборатори	Хийх ажил
Агаар	А. Төслийн талбай орчмын агаарын чанар Хянах зүйлс: Тоосний нийт агууламж мкг/м <sup>3</sup> , Азотын давхар исэл NO <sub>2</sub> мкг/м <sup>3</sup> , Хүхэрлэг хийн агууламж Хяналтын лавтагдал: Уурхай ажиллах хугацаанд Шинжилгээний байршил: Бутлагч орчим, Үйлдвэрийн пүү орчмоос.	MNS5246-2003.4.Х Агаар дахь радоны хэмжээг тодорхойлох арга, MNS4991-2000.10.х Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын бүсийн агаар дахь хорт бодисын концентрацыг хэмжих аргачлалд тавих шаардлага, MNS5365-2004.4.Х Агаарын чанарын ерөнхий асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга, MNS5885-2008.8.Х Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэххэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага, MNS3384-1982.3.Х Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага. MNS4048-1988.2.Х Байгаль хамгаалал. Агаар мандал. Тоосны хэмжээг жингийн аргаар тодорхойлох, MNS(ISC))4227-2002.23.х Хүрээлэн буй орчны агаарын чанар хяналтын төлөвлөгөө, MNS5631-2006.4.Х	Улаанбаатар хотын Цаг уур, орчны шинжилгээний газар, байгаль орчин, хэмжилт зүйн төв лаборатори.	- агаарын чанарын хэмжилт хийлгэсэн
Хөрс	Хянах зүйл: - Хөрсний бохирдлыг тогтоох: Кадьми, Хар тугалга, Мөнгөн ус, Хром. Хяналтын давтагдал: Жилд 1 удаа Хяналтын цэгүүд: Пүү орчим, Технологийн зам.	MNS5850 -2008.6.х Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS3298-1991.5.Х БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ. ХӨРС. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд. MNS(ISO)10390-2001,7.х Хөрсний чанар. рН тодорхойлох, MNS(ISO)I 1046-2003.19.х MNS(ISO)I 1269.2.2002.9.х Хөрсний чанар. Хөрсний ургамалд бохирдуулагчийн нөлөөлөллийг тогтоох.	Улаанбаатар хотын Цаг уур, орчны шинжилгээний газар, байгаль орчин, хэмжилт зүйн төв лаборатори.	-дээжлэлт, Лабораторийн шинжилгээ Газрын төлөв байдлыг шинжлэн судалж, хөрсний чанарыг үнэлэх
Газрын доорхи ус	А. Гүний усны чанар Хянах зүйл: Гидрохими. хүнд металл. хатуулаг /рН/, Cl, SO <sub>4</sub> <sup>2-</sup> , NO <sub>2</sub> , NO-Т, CO <sub>3</sub> , HCO <sub>3</sub> <sup>-</sup> " Хяналтын давтагдал: Жилд 2 удаа Хяналтын цэгүүд: нийт 3 цэгт	MNS(ISO)5667.1.2002.22.х Усны чанар. Дээж авах. 1-р хэсэг: Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар MNS(ISO)5667.2.2001.14.х Усны дээж. Дээж авах. 2-р хэсэг. Дээж авах аргачлалын заавар MNS4586 -1998.3.Х Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага	-Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар төв лаборатори. -"Инженер геодези"ХХК-ын Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори.	Дээжлэлт, Лабораторийн шинжилгээ Усны чанарыг үнэлэх

Ажлын байрны эрүүл ахуй	А. Ажлын байрны нөхцөл Хянах зүйл: Ажлын байрны эрүүл ахуй, Гэрэлтүүлэг, Хөдөлмөр хамгаалах, аюулгүй ажиллагааны иж бүрэн хэрэгсэл, Галын аюулгүй байдлын арга хэмжээ, Иргэний хамгаалалтын арга хэмжээний төлөвлөлт Хяналтын давтагдал: Жилд 2 удаа	Хөдөлмөрийн эрүүл ахуйн нэгдсэн дүрэм	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажил хийгдэж байна.	Ажлын байрны эрүүл аюулгүй орчинд ажиллах байдлыг хангах
	Ажилтан ажиллагсдын эрүүл мэндийн байдал		СХД-ийн эмнэлэгээр хийлгүүлсэн.	Эрүүл мэндийн нэгдсэн үзлэгт хамруулах

2022 онд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт зарцуулсан зардлын хэмжээ

№	Ажлын нэр	Жилд хийлгэх шинжилгээний тариф	Нэг жилийн нийт шинжилгээний зардал /мян.төг/
1	Агаарын сорьц шинжилгээ хийлгэх	Уурхайн ажиллах хугацаанд	197.0
2	Усны шинжилгээ хийлгэх	2 цэгт * 1 удаа	
3	Хөрсний шинжилгээ хийлгэх	2 цэгт * 1 удаа	
4	Бусад зардал		
	Нийт дүн		197.0

-Худгийн усны дээжийг лабораторийн шинжилгээнүүд хийлгэсэн байгаа.



## Дүгнэлт

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баримлан гүйцэтгэн ажилласан бөгөөд 2023 онд байгаль орчны чиглэлд манай компани онцгой анхааран ажиллах болно.

**2022 онд байгаль орчны менежментийн чиглэлээр доорх зардлуудыг зарцуулав.**

Үүнд:

Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт арга хэмжээ	-2 880 000₮
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	-197 000₮
Олон нитэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө	-250 000₮
Удирлага зохион байгуулалт	-510 000₮
<b>Нийт:</b>	<b>-3 837 000₮</b>